



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОМА-2023/85/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Даланзадгад хот 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn Аудитор: С.Одончимэг Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.02.24 № 86

танай _____-ны № _____-т

МАНДАЛ-ОВОО СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Т.НАРАНХИШИГ
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мандал-Овоо сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Мандал-Овоо сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бичиг хэргийн ажилтны орон тоог илүү баталсан, сургуулийн багш, ажилчдад шалгуур үзүүлэлтгүй, ажлын гүйцэтгэл үр дүн харгалзалгүй үр чадварын нэмэгдэл цалин олгосон, он дамжсан авлагыг барагдуулаагүй, тайлант онд НДШ-ийн авлага, ХХОАТ-ын өглөг үүсгэсэн, зарим албан хаагчийн албан тушаалын цалинг зөрүүтэй тооцож олгосон, байгууллагын дотоод журмыг шинэчлэн батлаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.3, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/024/11 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив", Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10, 9 дугаар тушаалаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд үр чадварын нэмэгдэл

016020152

олгох шалгуур үзүүлэлт", Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалаар баталсан "Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 5-д заасантай тус тус нийцээгүй санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Шинээр 16.2 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, ашиглалтын хугацаа дууссан хөрөнгөд үнэ тогтоон 58.2 сая төгрөгөөр бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтад "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах санхүүжүүлэх аргачлал"-ын дагуу жилийн эцсийн дансны үлдэгдэл 35.8 сая төгрөгийг дараагийн төсвийн жилд шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>87,304,637.23</u>	<u>107,914,416.71</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	35,861,808.48
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	35,861,808.48
3121	Төгрөг	-	35,861,808.48
31211	Төрийн сангийн харилцах	-	35,861,808.48
33	АВЛАГА	1,248,055.00	1,531,555.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	283,500.00
335	Бусад авлага	1,248,055.00	1,248,055.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,248,055.00	1,248,055.00
35	БАРАА МАТЕРИАЛ	86,056,582.23	70,521,053.23
351	Түүхий эд материал	2,074,000.00	2,074,000.00
35130	Эм боох материал	2,074,000.00	2,074,000.00
354	Хангамжийн материал	83,982,582.23	68,447,053.23
35410	Бичиг хэргийн материал	27,546,103.00	16,712,703.00
35420	Аж ахуйн материал	53,377,549.23	49,238,350.23
35460	Хүнсний материал	908,530.00	1,896,600.00
35470	Бусад хангамжийн материал	2,150,400.00	599,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,312,555,773.39</u>	<u>1,250,097,229.71</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,312,555,773.39	1,250,097,229.71
392	Биет хөрөнгө	1,298,752,439.95	1,236,901,762.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,340,882,326.04	1,323,158,326.04
39202	Хуримтлагдсан элэгдэл	(225,476,034.36)	(279,178,918.44)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	44,500,000.00	31,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(32,999,999.84)	(15,333,333.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	129,126,725.00	122,426,475.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(64,289,592.70)	(49,173,236.79)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	135,750,190.00	133,457,440.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(64,245,429.22)	(66,092,344.89)
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,669,000.00	13,669,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,503,899.97)	(2,870,799.93)
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном	23,339,155.00	25,339,155.00
393	Биет бус хөрөнгө	13,803,333.44	13,195,466.84
39301	Програм хангамж	2,746,000.00	2,746,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(646,666.56)	(1,254,533.16)
39303	Бусад биет бус хөрөнгө	11,704,000.00	11,704,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН Ш=I+II	<u>1,399,860,410.62</u>	<u>1,358,011,646.42</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>210,006.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	210,006.00
413	Өглөг	-	210,006.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	210,006.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,399,860,410.62</u>	<u>1,357,801,640.42</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,399,860,410.62	1,357,801,640.42
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	838,317,602.00	838,317,602.00
51101	Өмч: - төрийн	838,317,602.00	838,317,602.00

512	Хуримтлагдсан үр дүн	(117,284,420.96)	(159,343,191.16)
51210	Өмнөх үеийн үр дүн	(117,284,420.96)	(117,284,420.96)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(42,058,770.20)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	678,827,229.58	678,827,229.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,399,860,410.62	1,358,011,646.42

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	611,528,678.00	673,764,489.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,774,789.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	79,500.00
120009	Бусад орлого	-	79,500.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	1,695,289.00
123004	Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,695,289.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	611,528,678.00	671,989,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	487,845,100.00	510,320,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	510,320,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	487,845,100.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,185,578.00	24,187,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,371,551.00	13,132,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	11,055,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,814,027.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	107,498,000.00	137,482,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	107,498,000.00	137,482,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	707,997,153.02	770,655,559.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	707,997,153.02	770,655,559.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	675,325,300.27	735,920,400.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	349,904,061.46	390,109,615.45
210101	Үндсэн цалин	349,904,061.46	390,109,615.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,518,219.79	49,327,860.07
210201	Тэтгэврийн даатгал	31,688,953.85	33,720,022.19
210202	Тэтгэмжийн даатгал	3,499,045.91	3,901,959.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,799,236.72	3,121,567.55
210204	Ажилгүйдлийн даатгал	683,094.55	780,391.92
210205	Эрүүл мэндийн даатгал	6,847,888.76	7,803,918.94

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102,044,609.00	104,829,307.00
210301	Гэрэл, цахилгаан	2,549,609.00	5,759,387.00
210302	Түлш, халаалт	97,710,000.00	97,709,920.00
210303	Цэвэр, бохир ус	1,785,000.00	1,360,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,542,145.00	9,622,874.00
210401	Бичиг хэрэг	5,068,200.00	-
210402	Тээвэр, шатахуун	4,596,430.00	3,851,375.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,343,256.00	-
210404	Ном, хэвлэл	428,299.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,985,960.00	1,889,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	120,000.00	3,881,999.00
2105	Нормативт зардал	6,031,020.00	18,322,850.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,765,350.00	-
210502	Хоол, хүнс	3,042,470.00	18,322,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	223,200.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,328,000.00	2,776,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	16,300.00
210604	Урсгал засвар	3,328,000.00	2,760,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	-
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,052,690.00	3,384,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,052,690.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	3,384,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	148,904,555.02	157,547,593.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,355,800.00	5,342,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,072,600.00	20,019,750.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	141,476,155.02	132,185,343.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,671,852.75	34,735,159.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,489,451.00	29,974,911.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,474,400.00	21,060,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,015,051.00	8,914,211.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,056,930.75	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,056,930.75	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,125,471.00	3,064,959.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,125,471.00	3,064,959.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,695,289.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,695,289.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(96,468,475.02)</u>	<u>(96,891,070.20)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(96,468,475.02)</u>	<u>(96,891,070.20)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	611,528,678.00	673,764,489.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,774,789.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	79,500.00
120009	Бусад орлого	-	79,500.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	1,695,289.00
123004	Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,695,289.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	611,528,678.00	671,989,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	487,845,100.00	510,320,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	510,320,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	487,845,100.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,185,578.00	24,187,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,371,551.00	13,132,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	11,055,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,814,027.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	107,498,000.00	137,482,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	107,498,000.00	137,482,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	580,770,221.00	621,647,780.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	580,770,221.00	621,647,780.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	549,341,295.25	588,952,121.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	349,904,061.46	389,899,609.45
210101	Үндсэн цалин	276,625,034.93	304,712,232.17
210102	Нэмэгдэл	54,180,963.12	64,764,716.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	800,000.00	-
210104	Урамшуулал	18,298,063.41	20,422,660.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,518,219.79	49,611,360.07
210201	Тэтгэврийн даатгал	31,239,993.00	35,580,787.76
210202	Тэтгэмжийн даатгал	2,895,000.00	4,004,410.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,387,976.79	2,532,690.24
210204	Ажилгүйдлийн даатгал	694,800.00	122,040.82
210205	Эрүүл мэндийн даатгал	7,300,450.00	7,371,431.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102,044,529.00	104,829,307.00
210301	Гэрэл, цахилгаан	2,549,609.00	5,759,387.00
210302	Түлш, халаалт	97,709,920.00	97,709,920.00
210303	Цэвэр, бохир ус	1,785,000.00	1,360,000.00

2104	Хангамж, бараа материалын зардал	20,842,745.00	-
210401	Бичиг хэрэг	6,970,000.00	-
210402	Тээвэр, шатахуун	4,596,430.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,343,256.00	-
210404	Ном, хэвлэл	428,299.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,504,760.00	-
2105	Нормативт зардал	12,706,050.00	19,310,920.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,119,350.00	-
210502	Хоол, хүнс	3,435,300.00	19,310,920.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,151,400.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,328,000.00	3,125,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	145,100.00
210604	Урсгал засвар	3,328,000.00	2,980,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	-
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,052,690.00	3,384,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,052,690.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	3,384,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,945,000.00	18,791,825.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,705,800.00	13,432,075.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,239,200.00	5,359,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,428,925.75	32,695,659.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,305,251.00	27,935,411.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,290,200.00	19,021,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,015,051.00	8,914,211.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,998,203.75	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,998,203.75	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,125,471.00	3,064,959.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,125,471.00	3,064,959.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,695,289.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,695,289.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	30,758,457.00	52,116,708.48
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	28,699,730.00	16,254,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,699,730.00	16,254,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	28,699,730.00	16,254,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,699,730.00	16,254,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(28,699,730.00)	(16,254,900.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	2,058,727.00	35,861,808.48
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	35,861,808.48

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	838,317,602.00	678,827,229.58	(117,284,420.96)	1,399,860,410.62
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	838,317,602.00	678,827,229.58	(117,284,420.96)	1,399,860,410.62
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(42,058,770.20)	(42,058,770.20)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	838,317,602.00	678,827,229.58	(159,343,191.16)	1,357,801,640.42

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	647,802,700.00	610,650,721.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	647,802,700.00	610,650,721.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	627,084,300.00	593,663,521.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	419,671,000.00	389,899,609.45
210101	Үндсэн цалин	320,123,400.00	304,712,232.17
210102	Нэмэгдэл	92,919,500.00	64,764,716.30
210104	Урамшуулал	6,628,100.00	20,422,660.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,115,100.00	49,611,360.07
210201	Тэтгэврийн даатгал	35,589,000.00	35,580,787.76
210202	Тэтгэмжийн даатгал	4,165,100.00	4,004,410.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,189,600.00	2,532,690.24
210204	Ажилгүйдлийн даатгал	797,500.00	122,040.82
210205	Эрүүл мэндийн даатгал	8,373,900.00	7,371,431.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	105,120,000.00	104,829,307.00
210301	Гэрэл, цахилгаан	5,760,000.00	5,759,387.00
210302	Түлш, халаалт	98,000,000.00	97,709,920.00
210303	Цэвэр, бохир ус	1,360,000.00	1,360,000.00
2105	Нормативт зардал	19,788,200.00	19,310,920.00
210502	Хоол, хүнс	19,788,200.00	19,310,920.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	2,980,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	2,980,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,384,200.00	3,384,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,384,200.00	3,384,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,005,800.00	23,648,325.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,645,300.00	18,288,575.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,360,500.00	5,359,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,718,400.00	16,987,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,718,400.00	16,987,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,718,400.00	16,987,200.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	647,802,700.00	644,737,741.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	510,320,200.00	510,320,200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	510,320,200.00	510,320,200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	137,482,500.00	134,417,541.00
132001	Орон нутгийн төсвөөс	137,482,500.00	134,417,541.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		35,861,808.48

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,491,711.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,491,711.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,543,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,543,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,543,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,948,211.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,948,211.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,034,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,914,211.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,695,289.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,695,289.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	24,187,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,187,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,132,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,055,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 23.6 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 23.6 сая төгрөгийн алдааг залруулж ажилласан. Үүнд:

- Орлого үр дүнгийн тайланд буцсан гүйлгээг устгах бичилт хийгээгүй, 210901 бараа ажил үйлчилгээний зардлаас зарцуулсан хөрөнгийг зардлын зүйл ангиар тайлагнаагүй байна
- Тус сургуулийн захирлын 2022 оны А/14 дүгээр тушаалаар байгууллагын эргэлтийн хөрөнгөөс ашиглалтын шаардлага хангахгүй 31 төрлийн 15.3 сая төгрөгийн акталсан бараа материалыг орлого үр дүнгийн тайланд бараа материал акталсны зардлаар, бараа материалын тодруулга тайланд салгаж тайлагнаагүй байна.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй байна.

5.2 Албан шаардлага

Мандал-Овоо сумын ЕБС-ийн 2022 оны А/01 дугаар тогтоолоор бичиг хэргийн орон тоо нэмж баталж, сургуулийн номын санчид, бичиг хэргийн ажил хавсруулан гүйцэтгүүлж нэмэгдэлд 2.0 сая төгрөгийн цалин олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6 "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/024/11 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Тус сургуулийн багш, ажилчдад шалгуур үзүүлэлтгүй, ажлын гүйцэтгэл үр дүн харгалзалгүй нийтдээ 5.1 сая төгрөгийг ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6 "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох", Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10, 9 дугаар тушаалаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт", Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалаар баталсан "Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 5-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Санхүү хяналтын актаар 2017 онд үүссэн 1.3 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тайлант онд НДШ-ийн 0.3 сая төгрөгийн авлага, 0.2 сая төгрөгийн ХХОАТ-ын өглөг үүсгэж ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Сургалтын хэрэглэгдэхүүн, зөөлөн эдлэл, гал тогооны хэрэгслүүдийг аж ахуйн материалын дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 /үнэн зөв байх/ болон санхүүгийн тайлагналын ангилал гэсэн баталж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: УСНББОУС 1,12 дагуу бүртгэл хөтөлж, бараа материалыг зохих ангилал, дансанд залруулж ажиллах

Илрүүлэлт 2: Байгууллагын дотоод журмыг Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлж шинэчлэн боловсруулаагүй, хоол унаа нөхөх төлбөр олгох талаар дотоод журамд тусгаагүй хөрөнгө зарцуулж ажилласан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 "Ажил олгогч ажилтны төлөөлөгчийн саналыг харгалзан хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд үйлчлэх хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдүүлнэ"-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлж "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг шинэчлэн баталж, хууль эрхзүйн шийдвэр гаргаж ажиллах

Илрүүлэлт 3: Тус сургууль ТҮБД ангиллын 5 дугаар шатлалаар цалинжиж байсан 2 албан хаагчийн албан тушаалын цалинг 5 хувиар нэмэгдүүлээгүй, 5 хувийн нэмэгдэл цалин олгож ажилласан байна.

Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/122 дугаар "Төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай" тушаалын 2-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/122 тушаалын 2-д заасны дагуу албан тушаалын цалинг 5 хувиар нэмэгдүүлэн цалинг тогтоож ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитыг газарт 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого үр дүнгийн тайланд буцсан гүйлгээг устгах бичилт хийгээгүй, 210901 бараа ажил үйлчилгээний зардлаас зарцуулсан хөрөнгийг зардлын зүйл ангиар тайлагнаагүй байна	1	8,339.9			1	8,339.9	1	8,339.9				
Тус сургуулийн захирлын 2022 оны А/14 дүгээр тушаалаар байгууллагын эргэлтийн хөрөнгөөс ашиглалтын шаардлага хангахгүй 31 төрлийн 15,291.0 мянган төгрөгийн акталсан бараа материалыг орлого үр дүнгийн тайланд бараа материал акталсны зардлаар, бараа материалын тодруулга тайланд салгаж тайлагнаагүй байна	1	15,291.0			1	15,291.0	1	15,291.0				
Дүн	2	23,630.9			2	23,630.9	2	23,630.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сургалтын хэрэглэгдэхүүн, зөөлөн эдлэл, гал тогооны хэрэгслүүдийг аж ахуйн материалын дансанд бүртгэсэн байна	1	0					1	0				
Байгууллагын дотоод журмыг Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлж шинэчлэн боловсруулаагүй, хоол унаа нөхөх төлбөр олгох талаар дотоод журамд тусгаагүй хөрөнгө зарцуулж ажилласан байна.	1	0					1	0				
Тус сургууль ТҮБД ангиллын 5 дугаар шатлалаар цалинжиж байсан 2 албан хаагчийн албан тушаалын цалинг 5 хувиар нэмэгдүүлээгүй, 5 хувийн нэмэгдэл цалин олгож ажилласан байна	1	0					1	0				
Мандал-Овоо сумын ЕБС-ийн 2022 оны А/01 дугаар тогтоолоор бичиг хэргийн орон тоо нэмж баталж, сургуулийн номын санчид, бичиг хэргийн ажил хавсруулан гүйцэтгүүлж нэмэгдэлд 2,034.5 мянган төгрөгийн цалин олгосон байна.	1	2,034.5			1	2,034.5						
Тус сургуулийн багш, ажилчдад шалгуур үзүүлэлтгүй, ажлын гүйцэтгэл үр дүн харгалзалгүй нийтдээ 5,128.4 мянган төгрөгийг үр чадварын нэмэгдэл олгосон байна.	1	5,128.4			1	5,128.4						
Санхүү хяналтын актаар 2017 онд үүссэн 1,248.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тайлант онд НДШ-ийн 283.5 мянган төгрөгийн авлага, 210.0 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг үүсгэж ажилласан байна.	1	1,741.5			1	1,741.5						
Дүн	6	8,904.4			3	8,904.4	3	0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайланг хугацаанд 22 мэдээлэл хугацаа хоцруулсан, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг зохистой мэдээлээгүй, тухайн жилийн төсөв, дараа жилийн төсвийн төсөл, аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, 5 сая төгрөгөөс дээш зарлагын 7,000,000 төгрөгийн 1 ажил гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш орлогын 132,397,900 төгрөгийн 6 ажил гүйлгээ, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргаагүй байна.	1	139,397.9			1	139,397.9		
Дүн	1	139,397.9			1	139,397.9		